

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС ТҮҮНЭЭС ГАРАХ ДҮГНЭЛТҮҮД

Н.БАТНАСАН, Доктор, МУИС, ЭЗС-ийн Маркетинг Олон Улсын худалдааны
тэнхмийн орлогч эрхлэгч

Судлаач доктор Н.Батнасан нь 2003 оны Монгол Улсын Хүний Хөгжлийн Илтгэлийн редактор бөгөөд энэхүү илтгэлийг бичих явцад Хүний Хөгжлийн Индекс болон түүнд гарсан өөрчлөлтүүдэд тооцсон судалгааны үр дүнд үнэлэлт дүгнэлтийг гаргаж тавьсан байна. Судалгаанаас харахад 1990-2002 онуудын Хүний хөгжлийн индексийг хооронд нь харьцуулан авч үзсэн бөгөөд манай улс сүүлийн жилүүдэд Хүний Хөгжлийн Индексийн үзүүлэлтээр аажмаар өсөх хандлагатай байна. Монгол Улс нь дундаж наслалт болон боловсролын үзүүлэлтээр Дэлхийн бусад орнуудтай харьцуулахад харьцангуй дээгүүр хэмжээнд байгаа боловч нэг хүн амд ногдох ДНБ-ний үзүүлэлт нь хойш чангааж байгааг энэхүү судалгааны үр дүн харуулж байна. Монгол улсын Хүний Хөгжлийн Индексийг жил тутам тооцсон тооцооноос харахад цаашид өсөх хандлага ажиглагдаж байгаа боловч хот, хөдөө болон бүс нутгаар мэдэгдэхүйц зааг ялгаа ажиглагдаж байгааг харуулсан байна. Энэхүү зааг ялгааг багасгах Монгол улсын хот, хөдөөд хүний хөгжлийн адил тэгш боломжийг бүрдүүлэх, мөн хот, хөдөөд алинд ч хүмүүст амьдрах өргөн сонголтыг бий болгох боломжийг бүрдүүлэхэд шийдвэртэй алхам хийх ёстойг харуулахыг зорьжээ.

Нийгэм, эдийн засгийн нэг тогтолцооноос нөгөөд шилжих түүхэн шилжилт хийж буй өнөө үед улс орны өмнө хөгжлийн олон бэрхшээлтэй асуудлууд тулгарч байгаа боловч хүний эрх, эрх чөлөөг хангах, хүний хөгжлийг дэмжих үзэл баримтлалыг Монгол улс нийгмийн эргэлт буцалтгүй үйл явц болгож чадсан билээ. Шинжлэх ухаан, техник технологи, мэдээлэл, харилцаа холбооны хөгжил өндөр төвшинд хүрсэн хорин нэгдүгээр зуунд дэлхийн улс орнууд материаллаг нөөц баялагаар бус иргэдийнхээ хүний хөгжил, чадавхи, оюуны хүчээр өрсөлдөх болж, хүний хөгжлийн асуудлыг хөгжлийн стратеги бодлогын төвшинд авч үзэх болсон энэ хандлагаас Монгол улс хоцроогүй юм.

Хүний хөгжлийн үзэл баримтлал нь хөгжлийн стратегиудын хамгийн сүүлийн үеийн хувилбаруудын нэгд тооцогдож байна.

Улс орнуудын хөгжлийн эцсийн зорилго нь эдийн засгийг бус харин харъяат иргэдийнхээ хүний хөгжлийн чадавхи, боломж, амьдрах орчин нөхцөлийг нь товчоор хэлбэл хүнийг хөгжүүлэхэд оршино. Харин хүний хөгжлийн асуудлуудаа шийдвэрлэхийн тулд эдийн засгаа хөгжүүлэх шаардлагатай.

Тийм ч учраас улс гүрнүүд хөгжлийн эцсийн зорилгоо хэрхэн хэрэгжүүлж байгаагаа үнэлж цэгнэх, бусадтай харьцуулахад ямар түвшинд байгаагаа мэдэх зорилгоор хүний хөгжлийн индекс (ХХИ)-ийг тооцон гаргах болжээ.

Хүний Хөгжлийн индексийг тооцохдоо улс орнуудын хүн амын амьжиргааны чанар, хөгжлийн боломж, чадавхи, амьдрах орчин нөхцөл, боловсруулахад амар хялбар байдал гэх мэт олон зүйлсийг харгалзан үзсэн болох нь харагддаг. Товчоор хэлбэл, Хүний Хөгжлийн Индекс нь тухайн улс орон дахь хүний хөгжлийн байдлыг илтгэн харуулах үзүүлэлтүүдийн хялбаршуулсан систем юм.

Хүн амд хүргэж буй нийгмийн үйлчилгээний хүртээмж, тэдний амьжиргааны чанар, соёл боловсролын төвшин гэх мэт зүйлсийг илтгэн харуулдаг дундаж наслалтын индекс ба боловсролын индекс, худалдан авах чадвар хийгээд эдийн засгийнх нь хөгжлийн ерөнхий төвшинг илтгэн харуулах нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдхүүний (ДНБ) жишсэн индекс зэрэг гурван индексийн дунджаар тодорхойлогддог хүний хөгжлийн ерөнхий индексээрээ Монгол улс 2000 онд “Дэлхийн хүний хөгжлийн илтгэл” 2002-т үзүүлэлтүүдээ оруулсан 173 орноос 0.655 гэсэн индекстэйгээр 113-р байрыг эзэлжээ.⁷

Ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийг хөгжлийн чиг баримжаа болгон хөгжиж буй Монгол улсад сүүлийн арваад жилийн туршид үргэлжилсэн шилжилтийн үеийн эдийн засгийн хямрал, бэрхшээлүүд тус орны хүний хөгжилд ихээхэн таагүй нөлөөлөл үзүүлж, хүний хөгжлийн зарим нэгэн үзүүлэлтүүд өмнө хүрсэн төвшингөөсөө доошилсон. Гэвч улс орны макро эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, шилжилтийн үеийн зарим бэрхшээлүүдийг даван туулж байгаагийн үр дүнд хүний хөгжлийн индекс өсөх хандлагатай болсныг сүүлийн 5 жилийн хүний хөгжлийн индексийн үзүүлэлтүүдээс харж болох юм.

Хүснэгт № 1. Монгол улсын хүний хөгжлийн индекс

Онууд	1990	1992	1995	1998	1999	2000	2001	2002
Дундаж наслалт жилээр	63.7	96.5	60.4	1640	0.645	0.845	0.467	0.652
Бичиг үсэг тайлагдалтын хувь	62.8	97.7	54.3	1266	0.638	0.824	0.424	0.626
Сургалтанд хамрагдагсдын нийлбэр хувь	63.8	98.6	57	1267	0.647	0.849	0.424	0.635
Нэг хүнд ноогдох ДНБ	65.1	96.5	62	1356	0.669	0.85	0.435	0.651
Дундаж наслалтын индекс	63.2	97.8	66	1706	0.636	0.872	0.472	0.661
Боловсролын индекс	63.2	97.8	69.6	1838	0.636	0.884	0.466	0.669
ДНБ-ны индекс	63.4	97.8	69.6	1968	0.636	0.884	0.497	0.674
Хүний хөгжлийн индекс	63.5	97.8	69.7	2125	0.642	0.884	0.51	0.679

Эх үүсвэр: “Монгол улсын хүний хөгжлийн илтгэл” 2000, ҮСГ-ын тоон мэдээлэл

Хүний хөгжлийн индексийг тооцож гаргасан 1990, 1992, 1995, 1998, 2000, 2001, 2002 онуудад индексүүд нь 0.652; 0.626; 0.635; 0.651; 0.662; хэмжээнд байснаас үзэхэд шилжилтийн эхний жилүүдэд индекс бага зэрэг унаад, сүүлийн жилүүдэд аажмаар өсөх хандлагатай болсон нь ажиглагдаж байна.

2002 оны “Дэлхийн хүний хөгжлийн илтгэл”-д дурдсанаар нэг хүнд ногдох ДНБ-ий жишсэн индекс нь 0.48, нэг хүнд ногдох ДНБ-ий бодит хэмжээ 390 ам.долларын⁸ төвшинд байсан ба Монгол улс эдгээр үзүүлэлтээрээ бага буурай орлоготой орнуудын ангилалд хамаарч байв. Хэдийгээр Монгол улс эдийн засгийн нөхцөл байдал нь хүндхэн байгаа боловч боловсролын төвшингээр, нэн ялангуяа бичиг үсэгт тайлагдалтын төвшингээр харьцангуй дээгүүрт ордог билээ.

Монгол улсын насанд хүрсэн нийт хүн амынх нь 97.8% бичиг үсэгт тайлагдсан⁹ нь дэлхийн дунджаас ихээхэн дээгүүр байгаа хэрэг юм.

Мөн онд Монголд боловсролын индекс нь 0.884¹⁰ байсан бөгөөд энэ үзүүлэлтээрээ дэлхийн дундажтай харьцуулахад мөн л дээгүүр төвшинд байна. Эдүгээ Монгол улс бүх нийтийн найман жилийн албан боловсролыг боловсролын минимум шаардлага болгоод байгаа юм.

⁷ Global Human Development Report 2002

⁸ Global Human Development Report

⁹ ҮСГ-ын тоон мэдээлэл

¹⁰ ҮСГ-ын тоон мэдээлэл

Хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалтын индекс Монгол улсад 0.636 байгаа¹¹ ба энэ үзүүлэлтээрээ дэлхийн дунджаас доогуур боловч бага орлоготой орнуудын дунджаас харьцангуй өндөр төвшинд хүрчээ.

Дурдсан баримтуудаас үзэхэд, өнгөрсөн зууны эхээр ертөнцийн хамгийн алс бөглүү хязгаарт тооцогдож байсан Монгол улс хүний хөгжлөөрөө эдүгээ дунд зэргийн хүний хөгжил бүхий улс орнуудын тоонд багтаж, хүний хөгжлийн индексээр хөгжиж буй улс орнуудын дунджаас давж гарчээ.

Сүүлийн арваад жилийн хүний хөгжлийн индексүүдээс үзэхэд Монгол улсын хүний хөгжилд зарим нэгэн өөрчлөлтүүд гарчээ. Хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин бага зэрэг дээшилж, бүх шатны сургуульд хамрагдаж буй хүмүүсийн суралцах насны хүн амд эзлэх хувийн жин 9.2%-иар өсчээ¹². Эдгээр өөрчлөлтүүдтэй уялдан боловсролын индекс мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн байна. Хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалтад онцын өөрчлөлт гараагүйгээс наслалтын индекс төдийлөн өөрчлөгдсөнгүй.

Харин нэг хүнд ногдох ДНБ-ий индекс 1990-ээд оны эхээр мэдэгдэхүйц хэмжээгээр буурч, хугацааны дунд үеэс бага зэрэг өсөх хандлагатай болжээ. Хүн амын боловсрол, орлогод гарсан эерэг өөрчлөлтүүдийн дүнд 90-ээд оны дунд үеэс хүний хөгжлийн индекс өсөх хандлагатай болжээ. Юутай ч гэсэн, өнөөдрийн байдлаар хүний хөгжлийн индекс Монголын эдийн засаг уналтад орж эхэлсэн шилжилтийн эхэн үеийн өмнөх хэмжээнээс давж гарсан байна.

Хүний хөгжлийн индекс, тэдгээрт гарсан өөрчлөлтүүд нь Монгол улс дахь хүний хөгжлийн өнөөнийн нөхцөл байдлыг бүрэн дэлгэн харуулж чадахгүй боловч дүгнэж үзвэл Монгол улсад хүний хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд нь ахин дэвших эерэг хандлагатай байгаа нь нотлогдож байна.

Сүүлийн жилүүдэд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ ба ХХИ-ийн аль аль нь өссөнөөс үзэхэд Монголд хүний хөгжлийн цаашдын өсөлтийг хангах эдийн засгийн өсөлт бүрдэх хандлага бий болж байна уу гэсэн горьдлого төрөхийн сацуу эдийн засгийнхаа өсөлтөд иргэдийнх нь хүний хөгжил түлхэц өгч юм болов уу гэсэн таамаглалыг төрүүлэх болов.

Хүнээ хөгжүүлэх талаар төрөөс баримталж буй бодлогын чиглэл нь сүүлийн жилүүдэд хүний хөгжлийн өсөлтийн чиглэлтэй давхцах болсноос үзэхэд Монгол улсад төрийн бодлого ба практикийн амьдралын нэгдэл бий болж байгаа бололтой.

Гэхдээ хүний хөгжлийн цаашдын бодлого төлөвлөлтөд тусгахгүй байж боломгүй, орхихгүй байж боломгүй тийм асуудлууд практикт ихээхэн хуримтлагджээ. Тэдгээрийн нэг нь хот, хөдөөгийн, бүс нутгуудын хүний хөгжлийн орчин нөхцөл, хүний боломж, чадавхид бодитой ялгаа үүсэн гарсан явдал билээ. Үүний нотолгоо нь бидний хийсэн тооцоогоор хүний хөгжлийн индекс хот, хөдөөгөөр бүс нутгуудаар харилцан адилгүй, ихээхэн ялгаатай түвшинд байсан явдал юм.

¹¹ УСГ-ын тоон мэдээлэл

¹² УСГ-ын мэдээлэл

2000 оны байдлаар Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудын хүний хөгжлийн индекс 0.701 байсан бол бусад аймгуудын дундаж нь 0.630 байв. Үүнээс үзэхэд Монгол орны хот, хөдөөд хүний хөгжлийн мэдэгдэхүйц зааг ялгаа нэгэнт үүсэн бүрэлджээ. Хүн амын наслалт(I_{ie}), боловсрол(I_{ed}), нэг хүнд ногдох (I_{GDP}) ДНБ-ийн жишсэн индексүүдийн тооцооноос үзэхэд хотуудын хүний хөгжил нь хөдөөгийнхөөсөө аль ч талаараа давуутай байна.

Хүснэгт 1. Монгол улсын хүний хөгжлийн индекс хот, хөдөөгөөр

Бүсүү д	I_{ie}	I_{ed}	I_{GDP}	HDI
Хот	0.65	0.92	0.553	0.71
Хөдөө	0.63	0.86	0.407	0.63
Нийт	0.64	0.88	0.486	0.66

Эх сурвалж: ҮСГ-ын мэдээлэлд тулгуурлан тооцоолов.

ҮСГ-ын мэдээлэлд тулгуурлан тооцсон бидний тооцоогоор Монголын хүн амын 57.87% нь нутаг дэвсгэрийн 36.87%-ийг нь эзэлдэг төмөр замын сүлжээ бүхий 9 аймаг ба нийслэлийн хүний хөгжлийн ерөнхий индекс 2000 онд 0.683 байсан бол төмөр замгүй аймгуудын дундаж нь 0.624 байлаа.

Хүснэгт 2. Монгол улсын 2000 оны хүний хөгжлийн индекс ба дэд бүтцийн хөгжилт

Бүсүүд	I_{ie}	I_{ed}	I_{GDP}	HDI
Төмөр замтай аймгууд	0.65	0.90 4	0.505	0.69
Төмөр замгүй аймгууд	0.62 7	0.85 6	0.408	0.63
Нийт	0.63 6	0.88 4	0.486	0.66

Эх сурвалж: ҮСГ-ын мэдээлэлд тулгуурлан тооцоолов.

Судалгааны үр дүн нь дээрх бүс нутгуудын хооронд хүний хөгжлийн мэдэгдэм ялгаа байгааг харуулж байна. Төмөр замтай бүс нутагт төрөлтөөс тооцсон дундаж наслалтын индекс 0.65, боловсролын индекс 0.904, нэг хүнд ногдох ДНБ-ий жишсэн индекс 0.495 байхад төмөр замгүй аймгуудад дээрх индексүүд харгалзан 0.627; 0.856; 0.387 байв. Судалгаанаас үзэхэд төмөр замгүй аймгуудын хүний хөгжлийг илтгэн харуулах хүний дундаж наслалт, боловсролын түвшин, нэг хүнд ногдох орлогын хэмжээ зэрэг үзүүлэлтүүд нь төмөр замтай аймгуудтай харьцуулахад харьцангуй доогуур түвшинд байна.

Хот, хөдөөгийн болон бүс нутгуудын ХХИ ялгаатай байгаагаас үзэхэд бодлого боловсруулагчид нөхцөл байдлыг анхааралдаа авч, цаашид гаргах шийдвэрүүддээ тусгаж үзэх шаардлага тулгамдсан асуудлын нэг болж байна. Хот хөдөөгийн аль алиных нь хүний хөгжлийн асуудалд хандах хандлага хаа хаанаа үгүйлэгдэж байна.

Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэсэн, хүний аюулгүй байдлыг хангахыг зорьсон хүн төвтэй хөгжлийн бодлого хэрэгжүүлж, зах зээлийн эдийн засагтай, иргэний ардчилсан нийгмийг байгуулахыг зорьж буй Монгол улсын хот, хөдөөд хүний хөгжлийн адил тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлд дорвитой ахиц дэвшил

гаргах нь хүний тогтвортой хөгжлийг хангах, түүний хот хөдөөгийн ялгаатай байдлыг ойртуулах, хот хөдөө хаана ч гэсэн хүмүүс өргөн сонголт хийх боломжийг бүрдүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой билээ.

Хүний Хөгжлийн асуудлаархи бодлого, хөтөлбөр, төслүүдийг боловсруулахдаа олон нийтийн хэрэгцээн дээр тулгуурлан төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих арга барилыг нэвтрүүлэх нь тэдгээрийн амьдрах чадварыг дээшлүүлэх үүднээс ач холбогдолтой. Энэ бол бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд баримтлах ёстой нэг чухал зарчим юм. Хүний хөгжлийн бодлого боловсруулна гэдэг нь хүний хөгжлийн хамгийн сайн боломжуудад тулгуурлан хөгжлийн зорилго, зорилтуудыг дэвшүүлж, төрийн зохицуулалтын арга хэрэгслүүдийн тусламжтайгаар хэрэгжүүлэх шат дараалал, цаг хугацаа, эзэн хариуцагчийг нь тодорхойлж, хяналтын тогтолцоог нь тогтоон, хөгжлийн бусад бодлого хөтөлбөрүүдтэй уялдуулах үйл ажиллагаа бололтой.